- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 870152.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7687.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 625713.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12514.3 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 930510.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 127491.8 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна. Өмнөх оны

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	19,726.50	63,672.10	43,945.60
Мөнгөн хөрөнгө	0	0	0.00
Авлага	2400.7	10,418.70	8,018.00
Урьдчилгаа	0	0	0.00
Бараа материал	17,325.70	53,253.40	35,927.70
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	783,292.40	866,838.70	83,546.30
Үндсэн хөрөнгө	925,308.90	1,027,790.00	102,481.10
Хуримтлагдсан элэгдэл	-142,016.40	-160,951.20	-18,934.80
Нийт хөрөнгө	803,019.00	930,510.80	127,491.80
Өр төлбөр	335.7	10808.00	10,472.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	802,683.20	919,702.80	117,019.60
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	803,019.00	930,510.80	127,491.80

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд авлага дансны эхний үлдэгдэл 2400.7 мянган төгрөг байсан ба харин тайлант хугацааны эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар “ Дэвших болор ” ХХҮ-аас “Ухаалаг самбар” худалдан авахаар мөнгийг шилжүүлсэнтэй холбоотой 9950.0 мянга, цалингийн ашгийн зөрүүг давтан тооцож ажилчдад давхар хөнгөлөлт үзүүлсэн байсантай холбоотой 533.7 мянга нийт 10418.7 төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53253.4 мянган төгрөг болж 35927.7 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуй материалын дансанд 8507.0 мянган төгрөгийн дадлага хичээлийн хэрэглэгдэхүүн дээд газрын шилжүүлгээр үнэ төлбөргүй ирж, төсвийн хөрөнгөөр 18497.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, аж ахуй материалын дансанд Covid-19 цар тахалтай холбоотой эм эмнэлгийн хэрэгсэл болон бусад материал хэрэгсэл худалдан авч тусгаарлах байр бэлдсэнтэй холбоотойгоор өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1027790.0 мянган төгрөг болж 102481.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11758.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 105646.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 108 дугаар тогтоолоор 222.6 мянган төгрөгийн ашиглалтгүй программ хангамж акталж, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2020.07.07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 15781.2 мянган төгрөгийн хөрөнгийг эргэлтийн хөрөнгө дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 105646.8 мянга, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 11758.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 919702.8 мянган төгрөг болж 117019.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 117019.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 742732.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 247143.3 мянган төгрөгөөр буюу 33 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын дээд газрын хөрөнгө оруулалтаар 115683.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор өмнөх оноос нэмэгдсэн, тусламж санхүүжилтийн орлого 35353.0 мянган төгрөг нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 97850.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 18419.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн

дансаар хүлээн авсан орлого 20677.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 625713.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 133223.2 мянган төгрөгөөр буюу 21 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 68565.5 мянган төгрөг, НДШ 13071.1 мянган төгрөг, түлш халаалтын зардал 32633.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 7924.5 нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 653053.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 653053.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65753.6 мянган төгрөгөөр бууруулж 587300.2 мянган төгрөгөөр анхны төсөв батлагдаж ирсэн ба 2020.12.31-ны байдлаар 584032.0 мянган төгрөг болж төсөв баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 584032.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 483255.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 100595.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 471716.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 100595.6 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 572311.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 572311.7 мянган төгрөгийг зарцуулж 11720.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 572311.7 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 9656.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 662.5 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 181.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 68.8 мянга, нормативд зардлыг 8166.8, эд хогшил, урсгал засварын зардлыг 16.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 45.0 мянга, төрөөс иргэдэд олгох дэмжлэг үзүүлэх зардлын 2005.8 мянга, нормативд зардлыг 8166.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 122.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 181.3 мянга, 81801 арга хэмжээ 2005.8 мянга, 81806 арга хэмжээ 8166.8 мянга, 81834 арга хэмжээ 9656.7 мянга, 81835 арга хэмжээ 122.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

#### Хүснэгт. 2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр арга хэмжээгээр/

мянган.төг

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
	<b>НИЙТ</b>	<b>584,032,000.00</b>	<b>572,311,751.81</b>	<b>11,720,248.19</b>		
1	Хөтөлбөр 71802	Ерөнхий боловсрол	572,123,900.00	560,403,697.81	11,720,202.19	98.0
2	Арга хэмжээ 80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	100,777,000.00	100,595,664.19	181,335.81	99.8
3	210301	Гэрэл, цахилгаан	2,949,300.00	3,592,974.19	-643,674.19	121.8
4	210302	Түлш, халаалт	94,206,700.00	93,600,790.00	605,910.00	99.4
5	210303	Цэвэр, бохир ус	621,000.00	401,900.00		64.7
6	210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
8	Арга хэмжээ 80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,260,600.00	1,253,050.00	7,550.00	99.4
9	213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	1,260,600.00	1,253,050.00	7,550.00	99.4
11	Арга хэмжээ 81801	үдийн цай хөтөлбөр	8,177,600.00	6,171,800.00	2,005,800.00	75.5
12	213205	Төрөөс иргэдэд олгох тэт, урам	8,177,600.00	6,171,800.00	2,005,800.00	75.5

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
14	<b>Арга хэмжээ 81806</b>	<b>Дотуур байрны үйлчилгээ</b>	<b>93,316,600.00</b>	<b>89,737,628.21</b>	<b>3,578,971.79</b>	<b>96.2</b>
15	210101	Үндсэн цалин	38,384,200.00	47,982,932.23	-9,598,732.23	125.0
16	210102	Нэмэгдэл	868,100.00	2,319,187.44	-1,451,087.44	267.2
17	210104	Урамшуулал	4,582,000.00	4,567,678.54	14,321.46	99.7
18	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	4,164,300.00	4,164,300.00	0.00	100.0
19	210202	Тэтгэмжийн даатгал	438,300.00	438,300.00	0.00	100.0
20	210203	ҮОМШ-ний даатгал	350,700.00	350,700.00	0.00	100.0
21	210204	Ажилгүйдлийн даатгал	87,700.00	87,700.00	0.00	100.0
22	210205	Эрүүл мэндийн даатгал	876,700.00	876,700.00	0.00	100.0*
23	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, зүйлс	646,800.00	646,800.00	0.00	100.0
24	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207,900.00	207,900.00	0.00	100.0
25	210502	Хоол, хүнс	41,116,000.00	26,501,730.00	14,614,270.00	64.5
26	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	623,700.00	623,700.00	0.00	100.0
27	210604	Урсгал засвар	970,200.00	970,000.00	200.00	100.0
29	<b>Арга хэмжээ 81834</b>	<b>Боловсролын стандарт, сургалтыг хэвийн явуулах үйчилгээ</b>	<b>233,644,700.00</b>	<b>227,735,295.01</b>	<b>5,909,404.99</b>	<b>97.5</b>
30	210101	Үндсэн цалин	118,448,300.00	110,730,447.00	7,717,853.00	93.5
31	210102	Нэмэгдэл	33,827,700.00	33,682,822.96	144,877.04	99.6
32	210104	Урамшуулал	19,701,300.00	23,793,925.05	-4,092,625.05	120.8
33	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	17,253,100.00	16,590,600.00	662,500.00	96.2
34	210202	Тэтгэмжийн даатгал	2,029,800.00	2,029,800.00	0.00	100.0
35	210203	ҮОМШ-ний даатгал	1,623,800.00	1,623,800.00	0.00	100.0
36	210204	Ажилгүйдлийн даатгал	405,900.00	405,900.00	0.00	100.0
37	210205	Эрүүл мэндийн даатгал	4,059,600.00	4,059,600.00	0.00	100.0
38	210401	Бичиг хэрэг	1,500,500.00	1,500,500.00	0.00	100.0
39	210403	Шуудан, холбоо, интернэт	1,009,300.00	670,400.00	338,900.00	66.4
40	210404	Ном, хэвлэл	1,393,800.00	761,800.00	632,000.00	54.7
41	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	503,300.00	503,300.00	0.00	100.0
42	210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,084,700.00	1,084,700.00	0.00	100.0
43	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,116,500.00	10,115,600.00	900.00	100.0
44	210601	Багаж, техник, хэрэгсэл	7,250,000.00	7,250,000.00	0.00	100.0
45	210604	Урсгал засвар	3,012,100.00	2,996,000.00	16,100.00	99.5
46	210702	Дотоод албан томилолт	1,400,900.00	957,000.00	443,900.00	68.3
47	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	724,400.00	679,400.00	45,000.00	93.8
48	210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.0
49	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
50	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	2,849,700.00	2,849,700.00	0.00	100.0
52	<b>Арга хэмжээ 81835</b>	<b>Сургалтын хэвийн үйл ажиллагаа</b>	<b>134,947,400.00</b>	<b>134,910,260.40</b>	<b>37,139.60</b>	<b>100.0</b>
53	210101	Үндсэн цалин	74,753,500.00	70,435,167.57	4,318,332.43	94.2
54	210102	Нэмэгдэл	7,782,500.00	10,998,943.79	-3,216,443.79	141.3
55	210104	Урамшуулал	23,328,300.00	24,384,109.04	-1,055,809.04	104.5
56	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	10,817,100.00	10,817,100.00	0.00	100.0
57	210202	Тэтгэмжийн даатгал	1,138,600.00	1,138,600.00	0.00	100.0
58	210203	ҮОМШ-ний даатгал	910,900.00	910,900.00	0.00	100.0
59	210204	Ажилгүйдлийн даатгал	227,700.00	227,700.00	0.00	100.0
60	210205	Эрүүл мэндийн даатгал	2,277,300.00	2,277,300.00	0.00	100.0
	210401	Бичиг хэрэг		21,000.00	-21,000.00	
61	210402	Тээвэр, шатахуун	3,100,000.00	3,320,550.00	-220,550.00	107.1
	210404	Ном, хэвлэл		750,000.00	-750,000.00	
62	210405	Хог хаягдал зайлуулах, хортон	311,500.00	231,490.00	80,010.00	74.3
63	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	300,000.00	290,500.00	9,500.00	96.8
64	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	10,000,000.00	9,877,900.00	122,100.00	98.8
65	<b>Хөтөлбөр 71806</b>	<b>Насан туршын болон албан бүс боловсрол</b>	<b>11,908,100.00</b>	<b>11,908,054.00</b>	<b>46.00</b>	<b>100.0</b>
66	<b>Арга хэмжээ 80101</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>11,908,100.00</b>	<b>11,908,054.00</b>	<b>46.00</b>	<b>100.0</b>
67	210101	Үндсэн цалин	10,356,600.00	10,356,600.00	0.00	100.0
68	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	983,900.00	807,700.00	176,200.00	82.1
69	210202	Тэтгэмжийн даатгал	103,600.00	279,800.00	-176,200.00	270.1
70	210203	ҮОМШ-ний даатгал	82,900.00	82,900.00	0.00	100.0
71	210204	Ажилгүйдлийн даатгал	20,700.00	20,700.00	0.00	100.0
72	210205	Эрүүл мэндийн даатгал	207,100.00	207,100.00	0.00	100.0
73	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	153,300.00	153,254.00	46.00	100.0

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас ажилчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 4197.8 мянган төгрөг, Наранмандал Энтерпрайзес ХХК-аас “Сайн багш” хөтөлбөрийн санхүүжилт 39000.0 мянган төгрөг орж ирснийг багш Б.Мөнхзул, Б.Эрдэнэ, Д.Өсөхбаяр, П.Энхзаяа, Ш.Пүрэвсамбуу нартай хийсэн 3 талт гэрээний дагуу ажлыг үнэлгээгээр улирал бүр тооцож 33387.5 мянган төгрөгийн урамшуулал олгож 692.5 мянган төгрөгийн поректор худалдан авч, сайн багшийн нэрэмжит уралдааны зардалд 1340.0 мянган төгрөг зарцуулж ХАОАТ-ын суутгалд 3580.0 мянган төгрөгийг суутган тооцож шилжүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухай бүр оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт.3 Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал							
Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Хугацаа хоцроосон мэдээллийн талаар
1	Бүтэн жил	11	11	5	4	2	Байгууллагын батлагдсан төсвийн мэдээлэл, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөл зэрэг 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	34			
5	Тухай бүр	8	96	96	2		Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт талаархи мэдээллийг 1,2-р сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.
	<b>Нийт</b>	<b>27</b>	<b>151</b>	<b>143</b>	<b>6</b>	<b>2</b>	

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1663.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй 1 зөвлөмжийг өгснийг 2020 оны 06 дугаар сарын 19-ны өдийн 1/36 тоот албан бичгээр ирүүлж 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14284.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 775.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 13509.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

#### **Залруулсан алдаа зөрчил**

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 775.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1 төлбөрийн

акт тогтоолоо. Үүнд:

Цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас түүн НДШ-ийн тайлантай тулгахад НД-ын байгууллагаас ирүүлсэн ААНБ-ын шимтгэл төлөлтийн жилийн эцсийн тайлангийн нэгтгэлээр 755.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй байхад НД-8 мэдээ тайлан болон тооцоо нийлсэн акт үйлдсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоож төлүүлэхээр шийдвэрлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 13509.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус сургуулийн хичээлийн шинэ байрыг гүйцэтгэгч Зүүн шанд ХХК нь 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 2020/05 дугаартай Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр хүлээлгэн өгсөн ба тус сургууль нь хичээлийн шинэ байрандаа сургалт хүмүүжлийн ажиллаа явуулж байсан бөгөөд ТӨБЗГ-ын шийдвэр гараагүй учраас тайланд орлогоор бүртгээгүй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх.

### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Балансын данстай холбоотой асуудал

**1.1. Илрүүлэлт:** "Дэвших болор" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй тул авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалттай нийцэхгүй байна.

**1.2. Эрсдэл:** Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

**1.3. Өгсөн зөвлөмж:** "Дэвших болор" ХХК хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашиггүй зарцуулахгүй байж цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

**2.1. Илрүүлэлт:** Бараа үйлчилгээний зардлаас Пи Си Толл ХХК-аас 1180.0 мянган төгрөгийн 2 ширхэг принтер, 1900.0 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютер, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас Цахир дэл хоршооноос 87.9 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, хичээл үйлдвэрлэлийн зардлаас Н.Золбаяраас 101.5 мянган төгрөгийн хогийн сав, Ц.Рэгзэдмаагаас 341.7 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, МЦЛ ХХК-аас 355.0 мянган төгрөгийн өргөмжлөл жааз нийт 3624.4 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч зардал хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралт бараа үйлчилгээний зардал хичээл үйлдвэрлэлийн зардал ангилал "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2. Эрсдэл:** Батлагдсан төсвийн зориулалт бусаар зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх.

**2.3. Өгсөн зөвлөмж:** Цаашид батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй, төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж зардал хооронд зориулалт бусаар гүйлгэн зарцуулахгүй ажиллах.

### 3. Зардлын данстай холбоотой асуудал

**3.1. Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл санхүүгийн тайланд 374197.5 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 99852.8 мянган төгрөгөөр буюу 274344.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.44. "Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ" гэснийг зөрчсөн байна.

**3.2. Эрсдэл:** Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй байх

**3.3. Өгсөн зөвлөмж:** Аймгийн ОНӨГ-т хандан 2012, 2016 онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангийн мэдээллийн дагуу дахин үнэлгээ дансны бүртгэлийн 274344,6 мянган төгрөгийн зөрүүг залруулах.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:	АУДИТОР	П.АМАРЖАРГАЛ	2021.02.18
Анхан шатанд хянасан:	ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР	А.ЦЭЭНЯМ	2021.02.18
Хоёр дахь шатанд хянасан:	ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Б.МӨНХБАТ	2021.02.18

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/26/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас түүн НДШ-ийн тайлантай тулгахад НД-ын байгууллагаас ирүүлсэн ААНБ-ын шимтгэл төлөлтийн жилийн эцсийн тайлангийн нэгтгэлээр 755.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй байхад НД-8 мэдээ тайлан болон тооцоо нийлсэн акт үйлдсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	775.4	Төлбөрийн акт тогтоох	Захирал, нягтлан бодогч	Ж.Болормаа, С.Түмэнжаргал
2	"Дэвших болор" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй.	9885.0	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ж.Болормаа, С.Түмэнжаргал
3	Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналаар 3 хөрөнгийн 99852.8 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл байхад санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 374197.5 мянган төгрөг буюу 274344.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ж.Болормаа, С.Түмэнжаргал
4	Бараа үйлчилгээний зардлаас Пи Си Толл ХХК-аас 1180.0 мянган төгрөгийн 2 ширхэг принтер, 1900.0 мянган төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютер, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас Цахир дэл хоршооноос 87.9 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, хичээл үйлдвэрлэлийн зардлаас Н.Золбаяраас 101.5 мянган төгрөгийн хогийн сав, Ц.Рэгзэдмаагаас 341.7 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, МЦЛ ХХК-аас 355.0 мянган төгрөгийн өргөмжлөл жааз нийт 3624.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	3624.4	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ж.Болормаа, С.Түмэнжаргал
<b>ДҮН</b>		<b>14284.8</b>			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_